

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2019 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД
ЯВЦЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2019.11.25

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2019 оны төлөвлөгөөнд 6 бүлгийн хүрээнд 175 заалтыг хэрэгжүүлэхээр тусган ажилласан байна. Үүнийг бүлгээр нь харуулбал:

Засаглалын хүрээнд – 35 заалт

Эдийн засгийн хүрээнд- 12 заалт

Нийгмийн бодлогын хүрээнд- 61 заалт

Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн хүрээнд- 25 заалт

Байгаль орчин, аялал жуулчлал, уул уурхайн хүрээнд – 20 заалт


Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын хүрээнд – 22 заалт тус тус хэрэгжиж байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг 2019 оны 11 сарын 15-ны байдлаар авч нэгтгэн, Засгийн газрын 2017 оны 03 сарын 15-ны өдрийн 89-р тогтоолоор баталсан БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ НИЙТЛЭГ ЖУРАМ-д заасан үнэлгээ өгөх зааврын дагуу үнэлж үзэхэд 175 заалтын биелэлтийн явц 85.9 хувьтай хэрэгжиж байна.


Хэрэгжилтийг ангилж үзвэл:

№	Үнэлгээний төрөл	Биелэлт тоогоор	Эзлэх жин
1	“үр дүнтэй”–зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан бол 100 хувь (90-100 хүртэл хувь)	115	65.7
2	тодорхой үр дүнд хүрсэн”-зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай бол 70 хувь (60-89 хүртэл хувь)	32	18.2
3	“эрчимжүүлэх шаардлагатай”-зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай бол 40 хувь (31-59 хүртэл хувь)	13	7.5
4	“үр дүнгүй”–зорилго, зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага зохион байгуулалт хангалтгүй бол 0 хувь (0-30 хүртэл хувь)	6	3.4
5	“үнэлэх боломжгүй”-зорилго нь тодорхойгүй, шалгуур үзүүлэлт нь шаардлага хангаагүй, эсхүл шалгуур үзүүлэлттэй боловч гүйцэтгэлийг үнэлэхэд хангалттай мэдээлэл байхгүй, төсөв хөрөнгө тодорхойгүй, гадаад хүчин зүйлээс шалтгаалсан зэргийг баримтаар нотолсон бол	9	5.2
Нийт		175	100


Хэрэгжилтийг графикаар харуулбал:



6 бүлгийн хэрэгжилтийг графикаар харуулбал:



Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтыг үндэслэн Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн дүгнүүлж байна. Өмнөх оны мөн үеэс 3,82 хувиар өссөн байна.




2019 онд төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн удаашралтай байгаа болон тасарч болзошгүй заалтуудын шалтгаан нөхцөлийг тодруулбал:



2019 ны төлөвлөгөөнд тусгагдсан 6 арга хэмжээ тасарч болзошгүй болон 0 хувьтай хэрэгжиж байна. Энэ нь төсөв хөрөнгө нь тодорхойгүй заалтууд байна.

Үүнийг салбараар нь харуулбал:



Эрчимжүүлэх шаардлагатай байгаа болон тасарч болзошгүй заалтуудыг хэлтэс, агентлагаар нь харуулбал:


№	Хэлтэс, агентлагуудын нэрс	40 хувь	0 хувь	Тайлбар
1	ХОХБТХ	7	-	40 хувьтай 7 заалт нь хөрөнгөнөөс 2, хугацаанаас 5 байна.
2	ХХААГ	1	2	40 хувьтай 1 заалт нь хөрөнгө, зохион байгуулалтаас болж байна. 0 хувьтай байгаа 2 заалт нь хөрөнгөнөөс шалтгаалан тасарч болзошгүй байна.
3	Дундговь ус	-	1	0 хувьтай байгаа 1 заалт нь хөрөнгөнөөс шалтгаалан удаашралтай хэрэгжиж байна.
4	БОАЖГ	1	-	40 хувьтай байгаа 1 заалт нь хөрөнгө, зохион байгуулалтаас шалтгаалан удаашралтай хэрэгжиж байна.
5	НБХ	1	-	40 хувьтай байгаа 1 заалт нь зохион байгуулалтаас шалтгаалан удаашралтай хэрэгжиж байна.
6	ЭМГ	-	2	0 хувьтай байгаа 2 заалт нь хөрөнгөнөөс шалтгаалан тасарч болзошгүй байна.
7	ГБХЗХГ	1	1	40 хувьтай 1 заалт нь хөрөнгөнөөс болж удаашралтай хэрэгжиж байна. 0 хувьтай байгаа 1 заалт нь зохион байгуулалтаас шалтгаалан тасарч болзошгүй байна.
8	БТСГ	2	-	40 хувьтай 2 заалт нь хугацаа, зохион байгуулалтаас шалтгаалан удааширч байна.
Нийт		13	6	

Дүгнэлт, зөвлөмж:

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2019 оны төлөвлөгөөний биелэлтийг 11 сарын 15-ны байдлаар авч Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2, 7.1 т заасны дагуу зорилт, арга хэмжээг үнэлэхдээ шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг хүрсэн түвшинтэй харьцуулан бодитой үнэлээг өгсөн эсэхэд явцын хяналт шинжилгээг хийлээ.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2019 оны төлөвлөгөөний 175 арга хэмжээг 85,9 хувьтай хэрэгжүүлж ажилласан буюу 147 арга хэмжээ нь тодорхой үр дүнд хүрч, боломжийн хэрэгжсэн байна. Үлдсэн 16 хувьд эрчимжүүлэх шаардлагатай, үр дүнгүй буюу үнэлэх боломжгүй байна гэсэн үзүүлэлт гарч байгаа нь цаашид төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх, хэрэгжилтэд анхаарах шаардлагатай байгааг харуулж байна.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд явцын хяналт шинжилгээг тасралтгүй, үнэлгээг хагас бүтэн жилээр хийж ажил эрчимжүүлэх талаар зөвлөмж өгч ажилласнаар төлөвлөгөөний хэрэгжилт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.82 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



Төлөвлөгөөнд туссан 175 арга хэмжээний 22 буюу 12,5 хувь нь Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын хүрээний арга хэмжээ байгаа бөгөөд хамгийн бага хувьтай хэрэгжиж байна. Энэ нь хөрөнгөнөөс болон хугацаандаа тендер зарлагдахгүй хугацаа хожимдуулсан ажлууд байгаагаас шалтгаалж байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС